


Ижил хос

Модны зангилаан дээр байх (a,b) хосыг дараах нөхцөл хангаж байвал ижил хос гээ.

1. a зангилаа нь b зангилааны өвөг дээдэс
2. $abs(a - b) \leq k$.

Зангилаанууд нь $1, 2, \dots, n$ гэсэн зүүлттэй модон дахь ижил хосын тоог олно уу.

Зурагт өгөгдсөн модны хувьд:



дараах өвөг дээдэс болон үр удмын хосууд гарна.

Pair	$abs(a-b)$	Pair	$abs(a-b)$
1,2	1	3,4	1
1,3	2	3,5	2
1,4	3	3,6	3
1,5	4		
1,6	5		

Хэрэв $k=3$ гэж өгвөл $abs(a-b) \leq 3$ нөхцөл хангах ижил хос 6 гарах нь.

Функцийн тодорхойлолт

Доорх редакторын цонхонд `similarPair` функцийг гүйцээн бичнэ үү. Энэ функц шалгуурт нийцэж буй хосын тоог илэрхийлэх ганц бүхэл тоог буцаана.

`similarPair` дараах параметруудтэй.

n : зангилааны тоог илэрхийлэх бүхэл тоо

k : өгсөн бүхэл тоо

`edges`: хоорондоо холбогдсон зангилааны зүүлтийг илэрхийлдэг хоёр бүхэл тооноос бүрдэх элемент бүхий хоёр хэмжээст массив.

Оролтын хэлбэр

Эхний мөрөнд зайгаар тусгаарлагдсан n ба k хоёр бүхэл тоо өгөгдөнө. Энд n нь зангилааны тоо, k нь ижил хосын босго юм.

Дараагийн $n-1$ мөрд хос тоонууд зайгаар тусгаарлан өгөгдөнө. Энэ нь $p[l]$, $c[l]$ ирмэгтэй гэдгийг илэрхийлэх бөгөөд

$p[l]$ нь эцэг зангилааны зүүлт бол $c[l]$ нь хүү зангилааны зүүлт юм.

Зааглалт

- $1 \leq n \leq 10^5$
- $1 \leq k \leq n$
- $1 \leq p[l], c[l] \leq n$

Гаралтын хэлбэр

Ижил хосын тоог илэрхийлэх ганц бүхэл тоо байна.

Жишээ

Оролт

5 2

3 2

3 1


1 4

1 5

Гаралт

4

Тайлбар



Нөхцөл хангах ижил хосууд (3,2), (3,1), (3,4), (3,5) байх учраас хариулт 4 юм.

(1,4), (1,5) хосууд байгаа боловч $\text{abs}(a-b) \leq k$ нөхцөлийг $k=2$ үед хангахгүй.

Орчуулсан : Р.Мижиддорж МУБИС, доктор